

**ХУВЬСГАЛЫН ӨМНӨХ МОНГОЛ ОРНЫ
НИЙГМИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ТУХАЙ
НЭГЭН СЭДЭВТ ЗОХИОЛ**

**Л. П. Попова. Общественная мысль
Монголии в эпоху «пробуждения
Азии» М., Наука, 1987-158 с.**

Зөвлөлтийн болон монголын эрдэмтдийн судалгааны нэгэн чухал чиглэл нь хувьсгалын өмнөх Монгол орны түүх билээ. 1921 оны ардын хувьсгалын өмнөх үе буюу XIX зууны сүүлч-XX зууны эхэн үеийн Монгол орны улс төр, нийгэм-эдийн засгийн байдал нэлээд гүнзгий судлагдсан бол тэр үеийн нийгмийн сэтгэлгээний судлал анхны алхмаа хийж хэл судлаач Г. Дэлэг нарын бүтээлүүд энэ чиглэлд судалгааны үндэс суурийг тавьж өгсөн юм. Гэвч өнөөг хүртэл Зөвлөлтийн монгол судлал XX зууны эхэн үеийн Монголын үзэл суртлын асуудалд бага анхаарч ирсэн нь илэрхий. Иймээс ч энэ үеийн монголын нийгмийн үзэл суртлын амьдралд феодалын ба шашны үзэл санаа бүрэн дүүрэн, хэмжээ хязгааргүй ноёрхож байсан тухай ойлголт удаан хугацааны турш амь бөхтэй явж ирсэн билээ. Тэгвэл Л. П. Поповагийн нэгэн сэдэвт зохиол нь тус оронд дэвшилт үзэл санаа хөгжиж ирснийг ул суурьтай гүн гүнзгий харуулж байна.

Монголын соён гэгээрүүлэлт, түүнээс үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд үзүүлсэн нөлөөг уг зохиолд нухацтай авч үзжээ. Монголын хувьд соён гэгээрүүлэх явдлыг тусгай асуудал болгон дэвшүүлсэн нь уламжлалт бус, өвөрмөц зүйл болсон бөгөөд цаашдын өргөн хэлэлцүүлгийг шаардах нь дамжиггүй.

Номонд ашигласан өргөн хүрээтэй архивын эх сурвалж, баримт бичиг нь эрдэм шинжилгээний эргэлтэд анх удаа орж байгаа төдийгүй феодалын нийгмийн хүрээнд дэвшилт үзэл санаа үүсэн бий болж хөгжин дэлгэрсэн үйл явцыг үнэмшилтэй үзүүлэх бололцоог олгож өгсөн байна. Зөвлөлтийн монгол судлалд анх удаа Монголын ууган тогтмол хэвлэл: «Нийслэл хүрээний сонин бичиг», «Шинэ толь» зэргийг нийтийн хүртээл болгосныг хэлэх хэрэгтэй.

Ардчилсан үзэл санаа агуулсан Монголын сэхээтний үзэл бодол хэрхэн бүрэлдэн тогтсон тухай зохиогч бичихдээ: «Тэдний үзэл бодол нь нэг талаас өөрийн эх орны дэвшилт үзэл санааны хөгжлийн үр дүнд, нөгөө талаас хөрөнгөтөн ёст Өрнөдийн шинэчлэлийн нөлөө болон 1905 оноос Оросын хувьсгалт хөдөлгөөний нөлөөний үр дагаврын дунд янз бүрийн эс элементийг нэгтгэх журмаар бүрэлдэн тогтжээ». (с.6)

«XX зууны эхэн үеийн Монголын нийгэм. Нийгэм-эдийн засгийн ба улс төрийн хөгжил» нэртэй нэгдүгээр бүлэгт хувьсгалын өмнөх Монгол оронд хот суурин газрын хүн ам бүрэлдсэн явдалд ихээхэн анхаарчээ. А. М. Позднеев, И. М. Майский, Ш. Нацагдорж, Ц. Пунцагноров нарын зохиолд тэмдэглэгдсэн хот суурины хүн амын тооны тухай баримт сэлтийг зохиогч харьцуулан задлан шинжилсэн байна.

Л. П. Поповагийн үзсэнээр, XIX зууны сүүл— XX зууны эхэн үеэр Монголын эдийн засагт ноцтой өөрчлөлт гарч феодалын харилцаа гүн, гүнзгий хямралд өртөхийн зэрэгцээ капиталист харилцааны үр хөврөл бий болж иржээ. Үзэл суртлын амьдралд ч гэсэн зохих хувьсал явагд-

сан байна. Хэдийгээр улс орны ёс суртахууны салбарт урьдын адил феодал-шашны үзэл суртал давамгайлж байсан боловч уламжлалт үзэл бодлын суурийг ганхуулах хэд хэдэн ахицтай хандлага ажиглагдаж байв. Тэдгээр нь олон улсын харилцаа болон капиталист зах зээлийн хүрээнд Монгол татагдан орох болсон, хот суурин газрын хүн ам ялгарч ирсэн, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлт ба Монголын тусгаар тогтносон улсын тухай үзэл санаа сэргэн мандсантай холбоотой юм.

Зохиогч хот суурин газрын хүн амын дунд давхарга болох түшмэд албан-хаагч, жижиг аж ахуйтан ба худалдаачид ялгарч гарч ирсэн үйл явцыг тодорхой авч үзжээ. Монголын жижиг албан хаагчид хэрхэн үүсэж бий болсон, ямар үүрэг гүйцэтгэсэн тухай асуудал цаашдын судалгаа шаардаж байгааг тэмдэглэжээ. Улс төр болон нийгмийн байгуулалд гарсан өөрчлөлтийг Л. П. Попова чухалчлан үзсэн байна. Монголын хар шар феодалын хоорондын улс төрийн тэмцэл болон Богд хаант Монголын засгийн газрын дотоод зөрчлийн тухай хэд хэдэн шинэ санал дэвшүүлжээ.

«Монголын феодалын үзэл суртал дахь дэвшилт хандлага» хэмээх хоёрдугаар бүлэгт шинэ төрж буй соён гэгээрүүлэх хандлагад феодал шашны албан ёсны үзэл суртал хэрхэн хандаж байсныг харуулсан байна. Феодал-шашны үзэл суртлын хүрээнд ч гэсэн мөн лам нарын «шинэчлэлт» хийх хөдөлгөөн болон тусгаар тогтносон Монгол улсаа сэргээн мандуулах зэрэг үзэл бодол өргөн дэлгэрснийг зохиогч тэмдэглэжээ.

Хот суурин газрын дунд давхаргын төлөлөгчдийн нийгэм-улс төр, түүх, гүн ухааны үзэл бодлыг гуравдугаар бүлэгт задлан шинжилсэн байна. Л. П. Поповагийн үзсэнээр, «Шинэ толь», «Нийслэл хүрээний сонин бичиг» зэрэг тогтмол хэвлэлийг тойрон хүрээлсэн бүрэлдэн буй болж байгаа монголын сэхээтний төлөөлөгчид» (с. 81) шинээр төрж буй соён гэгээрүүлэх урсгалын үндсэн хүчин болж өгчээ. Соён гэгээрүүлэгчид нь улс орны эдийн засаг, соёлын хоцрогдлыг даван туулах явдлыг тэргүүн зорилтоо болгож байв. Шарын шашин илт давамгайлж байсан нөхцөлд байгалийн түүхийн ухааны үндсэн мэдлэгийг сурталчлах нь туйлын чухал байлаа. Соён гэгээрүүлэгчид нь Монгол болон хөрш зэргэлдээ орны түүхийн зохиол бичих замаар монголчуудын үндэс угсаагаа гэсэн ухамсрыг хөгжүүлэхийг чармайж байв. Монголын соён гэгээрүүлэх урсгалын нэгэн чухал онцлог болох шашны эсрэг чиглэлийг зохиогч цохон тэмдэглэжээ. (с. 84) Гэхдээ тэд шарын шашныг биш, харин том толгой лам нар, сүм хийдийн эрх ямба, шунахай чанарыг голчлон шүүмжилж байсан байна.

Тэр үед нээгдсэн хар хүнийг сургах анхны төрийн сургуулиуд нь шинжлэх ухааны үндсэн мэдлэгийг түгээн дэлгэрүүлээд зогсохгүй, боловсролын салбарт дангаар ноёрхож байсан сүм хийдийн нөлөөг ихэд сулруулжээ. Соён гэгээрүүлэх үзэл санаа өргөнөөр түгэн дэлгэрсэн явдлыг Л. П. Попова «Монголын дэвшилт сэтгэгчдийн үзэл бодол дахь хөрөнгөт ёсны урсгалыг юуны өмнө өрнөдийн үзэл санааны нөлөө, Орос, Япон, бүгд найрамдах Хятад улсын биет жишээнд хамааруулан авч үзэх нь зохистой» гэж тайлбарласан байна. (с.92) Энэ тайлбар нь сонирхолтой шинэ зүйл боловч цаашдын судалгаа, үндэслэлийг шаардаж байгаа нь маргаангүй.

Л. П. Попова зохиолынхоо нэгэн бүлгийг монголын соён гэгээрлийн томоохон төлөөлөгч Ч. Дэмчигдорж (1863—1932), түүний гүн

ухаан, улс төрийн ном зохиолыг задлан шинжлэхэд зориулжээ.

Ч. Дэмчигдоржийн талаар анх философийн ухааны дэд эрдэмтэн Д. Дашжамц бичиж зарим бүтээлийг нь судалжээ. Монголын сэтгэгч Ч. Дэмчигдоржийн зохиол бүтээл Монголын соён гэгээрүүлэгчдийн нийтлэг хэв шинжийг тусгаснаас гадна тэр үеийн монголын нийгэм дахь шилжилтийн үеийн зөрчилтэй шинж чанарыг өөртөө шингээжээ. Түүний гүн ухаан, эдийн засаг, улс төрийн үзэл бодол бурхны шашин болон хүнийн сургаалын элементээс гадна соён гэгээрэл ба ардчиллын үзэл санааг холилдуулан тусган авснаараа онцлогтой. Л. П. Поповагийн саналаар бол «...Улс орноо аврах арга зам юуны өмнө хүн амын дунд шинжлэх ухааны мэдлэгийг түгээх, ариун санаа, шударга ёсны үзэл санааг сурталчлах, ёс суртахууны нийтлэг зарчмыг хэвшүүлэхэд оршино гэж Дэмчигдорж үзэж байжээ.» (с. 102)

Ч. Дэмчигдорж бүх нийтийн эрх тэгш боловсролын талыг тууштай баримтлан, боловсролын хэрэгт язгуур угсаагаар ялгаварлан хандахыг эрс эсэргүүцэж байв. Тэрээр нийгмийн хөгжил дэх гэр бүлийн үүргийг өндөр үнэлэн, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад их анхаарч байлаа. Ч. Дэмчигдоржийн үзэл санаа хүнлэг чанарыг эрхэмлэн дээдлэж ирсэн нь зохиогчийн бичсэнээс тодорхой байна.

Монголын төр засгийг 1919 онд устгасан явдал нь нийгмийн сэтгэлгээний түр зуурын боловч эрчимтэй хөгжлийн нэгэн үеийн дуусгавар болсноос гадна улс орны нийгмийн хөгжлийн тулгамдсан асуудлыг дан ганц соён гэгээрүүлэх замаар шийдэх боломжгүйг харуулж өгчээ. Гэвч соён гэгээрүүлэх үе шат нь 1921 оны ардын хувьсгалын бэлтгэл, цаашилбал хувьсгалын ардчилсан шатанд хувьсгалт-ардчилсан болон марксизмын үзэл санаа амжилттай түгэн дэлгэрэх үржил шимт хөрсийг тавьж өгсөн нь гарцаагүй юм.

Энэ ч утгаараа Л. П. Поповагийн нэгэн сэдэвт зохиол нь Дорнодахин, түүн дотор Монголын нийгмийн сэтгэлгээний асуудлыг сонирхон судалдаг эрдэмтдийн талархал анхаарлыг татаж байгаа нь зүйн хэрэг. Энэхүү зохиолд урьд нь хөндөгдөх төдий өнгөрч байсан хэд хэдэн асуудлыг шинээр дэвшүүлэн тавьснаараа зөвлөлтийн монгол судлалд нэгэн ахицтай алхам болсон гэж үзэх үндэстэй юм.

Ю. В. Кузьмин (Иркутск) Түүхийн ухааны дэд эрдэмтэн
Орчуулсан **Ц. Батбаяр**